

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 3 сарын 09-ний өдөр

№ 20/10

Улаанбаатар хот

Дотоод аудитор томилох тухай

Компанийн тухай Монгол Улсын хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18, 81.4.2 дэх хэсэг, “ЛэндМН ББСБ” ХК (“Компани”) -ийн дүрмийн 14 дүгээр зүйлийн 14.5.2 дэх хэсэг, Компанийн Төлөөлөн Удирдах Зөвлөл (“ТУЗ”)-ийн үйл ажиллагааны журмын 2 дугаар зүйлийн 2.9.4, ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооны 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн хурлын дүгнэлт, ТУЗ-ийн 2020 оны 3 дугаар сарын 09-ний өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн Дотоод аудиторын албан тушаалд Мөнхөө овогтой Оюун-Эрдэнэ (РД: ХЙ86032217)-ийг 2020 оны 3 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн томилсугай.
2. М.Оюун-Эрдэнийн цалин, урамшууллыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хороотой зөвшилцсөний үндсэн дээр тогтоохыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д зөвшөөрсүгэй.
3. Дотоод аудиторыг чиг удирдлагаар ханган, түүний үйл ажиллагаа, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллахыг ТУЗ-ийн дэргэдэх Аудитын Хорооны Дарга (Ж.Жаргалсүрэн)-д үүрэг болгосугай.
4. Энэхүү тогтоолын биелэлтийг хангаж ажиллах, Дотоод аудитор М.Оюун-Эрдэнэтэй Хөдөлмөрийн гэрээ болон нууцлалын гэрээ байгууллахыг Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар)-д даалгасугай.



ТУЗ-ИЙН ДАРГА:

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2020 оны 3 сарын 09-ний өдөр

№ 20/11

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
цахим хэлбэрээр хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйл, 65 дугаар зүйл, 76 дугаар зүйлийн 76.1.2, 76.1.3, 76.1.18 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 2 сарын 19-ний өдрийн 64 тоот тогтоол, Санхүүгийн зохицуулах хорооны 2020 оны 3 сарын 05-ны өдөр нийт хувьцаат компаниудад хандан хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл, зайны технологийг ашиглан хуралдуулах тухай мэдэгдэл (<http://www.frc.mn/a/3156>) болон Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журмын 3 дугаар бүлэг, “ЛэндМН ББСБ” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн 20/09 тоот тогтоол, 2020 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “ЛэндМН ББСБ” ХК (цаашид “Компани”)-ийн Төлөөн Удирдах Зөвлөлөөс 2020 оны 03 сарын 28-ны өдрийн 12:00 цагт хуралдуулахаар төвлөсөн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг Хувьцаа эзэмшигчдийг нэг дор олноор цуглуулахгүй байхаар буюу цахим хэлбэрээр зохион байгуулахаар шийдвэрлэсүгэй.
2. Энэхүү тогтоолын 1-г заасантай холбогдуулан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг цахим хэлбэрээр зохион байгуулж, зохион байгуулалтыг холбогдох хууль, тогтоомжид нийцүүлэн ажиллахыг Хурал зохион байгуулах комисс (Комиссын дарга М.Түвшинжаргал), Компанийн Гүйцэтгэх захирал (О.Болдбаатар) нарт тус тус үүрэг болгосугай.

